



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны үйл ажиллагааны  
төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлан

## ХЭНТИЙ АЙМГИЙН 2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

*Аймгийн төсвийн зарлагын гүйцэтгэл 84.6 хувь байна.*

**АУДИТЫН КОД: ХЭА-2023/01/НА-СТА-ТЕЗ**

Чингис хот 2023 он  
Цахим хуудас: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

**Тэргүүлэх аудитор:** Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112  
**Аудитын менежер:** Д.Оюунтуяа  
Утас: 99775390  
**Аудитор:** Ц.Хатанболд  
Утас: 91925552  
**Аудитор:** Б.Ариунаа  
Утас: 93032714

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг

[khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn) хаягаар авна уу

<p><b>Тайланг бэлтгэсэн:</b> Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p><b>Дарга, тэргүүлэх аудитор</b> Ч.Эрдэнэбаатар</p> <p><b>Аудитын менежер</b> Д.Оюунтуяа</p> <p><b>Аудитор:</b> Ц.Хатанболд Б.Ариунаа</p> <p><b>2023 оны 04 сар</b></p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70562147, 70562112 дугаарын утас, <a href="mailto:khentii@audit.gov.mn">khentii@audit.gov.mn</a> хаягаар харилцана уу.</p> <p><b>ХАЯГ:</b>Хэнтий аймгийн Хэрлэн сум, аймгийн ЗДТГ-ын байр, 317 тоот</p>	<p><b>ТАЙЛАНГИЙН АГУУЛГА</b></p> <p><b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</b></p> <p>Үндсэн мэдээлэл.....2</p> <p><b>БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ҮНДЭСЛЭЛГҮЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.</b></p> <p>1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 640.0 сая төгрөг, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 3,922.3 сая төгрөгөөр тус тус буурсан байна .....5</p> <p>1.2 Аймгийн төсвийн орлогод 2,002.6 сая төгрөгийн ААНОАТ-ын орлогыг урьдчилан авсан нь холбогдох журамд нийцэхгүй байна.....6</p> <p>1.3 Байгаль хамгаалах, Хоршоо хөгжүүлэх, Орон нутгийн хөгжлийн сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 471.9 сая төгрөгөөр өссөн байна.....9</p> <p><b>БҮЛЭГ 2. НИЙТ ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ 84.6 ХУВЬТАЙ БАЙНА.</b></p> <p>2.1 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын хэмнэлт 1,634.0 сая төгрөг, үүнээс 744.2 сая төгрөгийн хэмнэлт нь үндэслэлгүй төлөвлөлттэй холбоотой хэмнэгдсэн байна.....12</p> <p>2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт малын тоо толгойн албан татварын орлогоос үүссэн эх үүсвэрийг бүрэн төлөвлөхгүй байна.....16</p> <p>2.3 Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийн 68.8 хувийг насжилт өндөртэй авлага эзэлж байна.....19</p> <p><b>БҮЛЭГ 3. НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ</b></p> <p><b>БҮЛЭГ 4. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ</b></p> <p><b>БҮЛЭГ 4. ӨМНӨХ АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ</b></p> <p>Аудитын дүгнэлт.....20</p> <p>Зөвлөмж.....21</p> <p>Хавсралтууд.....22</p>
--	--

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	
<b>АИТХ</b>	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>АТӨЯХ</b>	Авто тээвэр өөрөө явагч хэрэгсэл
<b>БОАЖЯ</b>	Байгаль орчин аялал жуулчлалын яам
<b>БОНАТ</b>	Борлуулалтын орлогод ногдох албан татвар
<b>БТСГ</b>	Биеийн тамир спортын газар
<b>БХБС</b>	Барилга хот байгуулалтын сайд
<b>БХС</b>	Байгаль хамгаалах сан
<b>БШУС</b>	Боловсрол, Шинжлэх ухааны сайд
<b>ГБХЗХГ</b>	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
<b>ГХБХБГ</b>	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
<b>ЕБС</b>	Ерөнхий боловсролын сургууль
<b>ЖДБДС</b>	Жижиг дунд бизнесийг дэмжих сан
<b>ЗАА</b>	Захирагчийн ажлын алба
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>МУЕА</b>	Монгол улсын ерөнхий аудитор
<b>НББ</b>	Нягтлан бодох бүртгэл
<b>ОНӨА</b>	Орон нутгийн өмчийн алба
<b>ОНӨААТҮГ</b>	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
<b>ОНХНС</b>	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>СӨБ</b>	Сургуулийн өмнөх боловсрол
<b>СТСХ</b>	Санхүү төрийн сангийн хэлтэс
<b>СХС</b>	Сум хөгжүүлэх сан
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>ТЕНБ</b>	Төсвийн ерөнхий нягтлан бодогч
<b>ТТАМ</b>	Түгээмэл тархацтай ашигт малтмал
<b>ТТЗ</b>	Төсвийн төвлөрүүлэн захирагч
<b>УИХ</b>	Улсын их хурал
<b>ҮАГ</b>	Үндэсний аудитын газар
<b>ҮҮЗАУс</b>	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус
<b>ҮҮХХБ</b>	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар
<b>ҮХХ</b>	Үл хөдлөх хөрөнгө
<b>ХНХС</b>	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
<b>ЭМДС</b>	Эрүүл мэндийн даатгалын сан
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв

## Аудитын тайлан

### Ерөнхий зүйл

**Аудитын нэр:** “Хэнтий аймгийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”

**Аудитын код:** ХЭА-2023/01/НА-СТА-ТЕЗ

### Аудитын хийх үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

### Аудитын зорилт:

Хэнтий аймгийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, аймгийн ИТХ болон Засаг даргад хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх
2. Орон нутгийн төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулсан эсэх
3. Нэмэлт санхүүжилтийн талаар
4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх
5. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлж ажилласан эсэх

### Хамарсан хүрээ:

Аудитыг аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэнцэл, аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, Татварын орлогын гүйцэтгэлийн мэдээ болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан аудит хийв.

### Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, судалгаа тодруулга авах, баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг аргыг ашиглахаас гадна аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### Үндсэн мэдээлэл

Монгол Улсын Их хурлаас 2022 онд “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг шинэчлэн баталж, дагаж мөрдсөн ба түүнтэй холбоотой журам зааврыг Засгийн газраас баталж, заавар чиглэл өгсөн байна.

Монгол улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар Хэнтий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 11,865.4 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 7,856.3 сая төгрөгөөр тус тус баталсан бол Хэнтий аймгийн 2022 оны төсөвт 2 удаа тодотгол хийгдэж 63,761.5 сая төгрөгөөр баталсан бөгөөд энэ эх үүсвэрээр орон нутгийн төсвийн 165, төсөл сан 63 байгууллагуудыг санхүүжүүлсэн байна.

**БҮЛЭГ1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙНА.****1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 640.0 сая төгрөг, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 3,922.3 сая төгрөгөөр тус тус буурсан байна.**

Монгол улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар Хэнтий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 11,865.4 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 7,856.3 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 1,190.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 1,902.4 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Сангийн яам 2022 оны төсвийн жилийн суурь орлогыг 24,562.6 сая төгрөгөөр буюу өмнөх оноос 406.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн хянасан.

Аймаг, сумдын ИТХ-аар орон нутгийн төсвийн орлогын нийт эх үүсвэрийг 63,764.3 сая төгрөгөөр баталсан. Үүнд: Орон нутгийн төсвийн орлого 26,192.6 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 15,787.7 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 8,496.3 сая төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлого 2,996.1 сая төгрөг, бусад тусламж 10,291.6 сая төгрөг байна.

**Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний харьцуулалт**

Хүснэгт №1

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Сангийн яамнаас хянасан	Анх батлагдсан	Тодотгол-1	Зөрүү	Тодотгол-2	Зөрүү
А	1	2	3	4=3-2	5	6=5-3
Нийт орлого	24,562.64	26,192.63	26,398.82	206.18	26,543.48	144.66
Тусламжийн орлого	15,020.73	37,571.63	37,300.23	(271.40)	37,217.97	(82.26)
Санхүүгийн дэмжлэг	15,020.73	15,787.73	15,787.73		11,865.43	(3,922.30)
ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг		8,496.31	8,496.31		7,856.29	(640.01)
Өөрийн орлого		2,996.06	2,996.06		2,214.55	(781.51)
Бусад тусламж		10,291.54	10,020.14	(271.40)	15,281.69	5,261.56
<b>ДҮН</b>	<b>39,583.37</b>	<b>63,764.27</b>	<b>63,699.05</b>	<b>(65.22)</b>	<b>63,761.45</b>	<b>62.40</b>

Сангийн яамны хянасан суурь орлогыг 1,630.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн аймгийн төсвийн нийт орлогыг 26,192.6 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

Аймгийн төсвийн орлогыг газрын дуудлага худалдааны орлого 170.0 сая төгрөг, торгуулийн орлого 120.0 сая төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 100.0 сая төгрөг нийт 390.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Сумын татварын орлогыг цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг 580.0 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 3.0 сая төгрөгөөр, урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагналыг 0.5 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 6.7 сая төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 36.3 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 28.8 сая төгрөгөөр, газрын төлбөрийг 41.5 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 269.1 сая төгрөгөөр, малын тоо толгойн албан татварыг 559.7 сая төгрөгөөр, торгуулийн орлого 25.0 сая төгрөгөөр, бусад орлогыг 88.0 сая төгрөгөөр нийт 1,638.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, үйл ажиллагааны орлогыг 307.3 сая төгрөгөөр, төсвийн байгууллагын орлогыг 91.3 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

МУ-ын 2022 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор төсвийн тодотголыг 2 удаа хийж, батлагдсан төсвийг эхний тодотголоор 65.2 сая төгрөгөөр бууруулан, сүүлийн тодотголоор 62.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 63,761.5 сая төгрөгөөр баталсан.

Төсвийн тодотголоор орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 640.0 сая төгрөгөөр, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 3,922.3 сая төгрөгөөр бууруулсан байна.

**1.2 Аймгийн төсвийн орлогод 2,002.6 сая төгрөгийн ААНОАТ-ын орлогыг урьдчилан төвлөрүүлсэн нь холбогдох журамд нийцэхгүй байна.**

Аймгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөөг 26,530.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 32,323.6 сая төгрөгийг төвлөрүүлэн, 5,793.6 сая төгрөг буюу 121.8 хувиар давж биелсэн байна.

Аймгийн төсвийн орлогын биелэлт /нэр төрлөөр/

Хүснэгт №2

(сая төгрөгөөр)

д/д	Орлогын төрөл	Орлого			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Зөрүү
А	1	2	3	4	5
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	-	631.4		631.44
2	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(830.0)	(638.9)	76.98	191.06
3	ҮХХ-ийн албан татвар	-	75.4		75.41
4	АТБӨЯХ-ийн албан татвар	463.0	645.1	139.33	182.11
5	ААН-ийн татвар	8,360.0	6,688.0	80.00	(1,672.00)
6	Газрын төлбөр	-	101.5		101.47
7	Газрын дуудлага худалдаа	420.0	1,179.2	280.77	759.23
8	ҮҮЗАУС-ны төлбөр	900.0	963.6	107.07	63.63
9	Улсын тэмдэгтийн хураамж	163.1	164.7	101.02	1.67
10	Хүү торгуулийн орлого	120.0	530.3	441.93	410.31
11	Бусад орлого	344.4	950.3	275.97	605.99
12	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө худалдсаны орлого	100.0	436.9	436.88	336.88
<b>Аймгийн орлогын дүн</b>		<b>10,040.4</b>	<b>11,727.6</b>	<b>116.80</b>	<b>1,687.19</b>
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	9,394.0	10,440.1	111.14	1,046.10
2	Үйл ажиллагааны орлого	568.1	668.2	117.62	100.10
3	Хөрөнгийн орлого/хад.хүү.ор/	1,175.5	1,052.0	89.50	(123.46)
4	ҮХХБ Орлого /2 хувь/	201.0	281.8	140.21	80.82
5	БОНАТ	0.5	1.0	200.42	0.50
6	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	464.0	539.4	116.24	75.37
7	Галт зэвсгийн албан татвар	48.8	49.0	100.36	0.18
8	Малд ногдуулах албан татвар	912.2	1,303.4	142.89	391.27
9	Улсын тэмдэгтийн хураамж	78.0	98.9	126.83	20.92
10	ТТАМ	99.3	87.5	88.11	(11.81)
11	Хог хаягдлын хураамж	501.3	566.2	112.95	64.92
12	Газрын төлбөр	782.5	845.1	108.01	62.65
13	Ойн нөөц ашигласны төлбөр	271.8	1,575.8	579.77	1,304.03
14	Агнуурын нөөц ашигласны төлбөр	530.4	1,543.5	291.00	1,013.07
15	Ус рашаан ашигласны төлбөр	-	5.2		5.23
16	Торгууль	748.5	925.6	123.66	177.06
17	Бусад орлого	713.8	613.3	85.92	(100.51)
<b>Сумын орлогын дүн</b>		<b>16,489.6</b>	<b>20,596.0</b>	<b>124.90</b>	<b>4,106.44</b>
<b>Нийт орлогын дүн</b>		<b>26,530.0</b>	<b>32,323.6</b>	<b>121.84</b>	<b>5,793.64</b>

Аймгийн төсөвт төвлөрөх орлогыг 10,040.4 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 11,727.6 сая төгрөг буюу 116.8 хувиар давж биелсэн байна. ААНОАТ-аас бусад татвар бүгд биелсэн байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.1, 23.6.10 заалтад нэмэлт өөрчлөлт орж, ААНОАТ-ын 60 хувийг улсын төсөвт, 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тусгасан. Уг өөрчлөлтийн дагуу ААНОАТ-ыг 8,360.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 6,688.0 сая төгрөг буюу 80 хувьтай байна. ААНОАТ-ын гүйцэтгэлд урьдчилж авсан орлогын 2,002.6 сая төгрөг орсон байна. Энэ нь Сангийн сайдын 2022 оны А7 тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг аймаг, нийслэлийн төсөв хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын 3.7 “2022 оноос өмнөх татварын нэхэмжлэлийн дагуу төлсөн болон хяналт шалгалтын нөхөн татвараар ногдуулсан аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг аймаг, нийслэлийн төсөв хуваарилахгүй” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Сумдын төсвийн орлогын гүйцэтгэл нийт дүнгээр 20,596.0 мянган төгрөг буюу 124.9 хувиар давж биелсэн байна.

## Сумдын төсвийн орлогын биелэлт /нэр төрлөөр/

Хүснэгт №3

(сая төгрөгөөр)

д/д	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Орлого Биелэлт	Зөрүү	Дүнд эзлэх хувь
А	1	2	3	4	5	6
1	Галшар	311.5	291.4	93.5	(20.1)	1.4
2	Баянхутаг	205.8	413.4	200.9	207.6	2.0
3	Баянмөнх	185.8	305.2	164.3	119.4	1.5
4	Дархан	635.9	649.6	102.2	13.7	3.2
5	Дэлгэрхаан	360.5	665.1	184.5	304.6	3.2
6	Хэрлэн баян улаан	45.2	61.8	136.7	16.6	0.3
7	Жаргалтхаан	668.2	754.8	113.0	86.6	3.7
8	Цэнхэрмандал	510.3	498.9	97.8	(11.4)	2.4
9	Өмнөдэлгэр	491.2	1,209.3	246.2	718.1	5.9
10	Гурванбаян	115.9	189.8	163.8	73.9	0.9
11	Батширээт	297.3	1,058.0	355.9	760.7	5.1
12	Биндэр	377.4	526.2	139.4	148.8	2.6
13	Баян-Адарга	302.8	326.4	107.8	23.6	1.6
14	Дадал	558.2	723.8	129.7	165.6	3.5
15	Норовлин	241.7	439.8	182.0	198.1	2.1
16	Батноров	434.7	582.5	134.0	147.8	2.8
17	Бэрх	285.6	401.4	140.5	115.8	1.9
18	Баян-Овоо	209.3	484.8	231.6	275.5	2.4
19	Бор-Өндөр	4,185.1	4,310.8	103.0	125.7	20.9
20	Мөрөн	254.8	352.9	138.5	98.1	1.7
21	Хэрлэн	5,682.1	6,237.7	109.8	555.6	30.3
22	Өлзийт	130.3	112.4	86.3	(17.9)	0.5
<b>Дүн</b>		<b>16,489.6</b>	<b>20,596.0</b>	<b>124.9</b>	<b>4,106.4</b>	<b>100.0</b>

Сумдын татварын орлогын биелэлтийг нэр төрөл, сумдаар авч үзвэл:

- Галшар сумын татварын орлогын гүйцэтгэл 93.5 хувь буюу 20.1 сая төгрөг, Цэнхэрмандал сумын татварын орлогын гүйцэтгэл 97.8 хувь буюу 11.4 сая төгрөг, Өлзийт тосгоны татварын орлого 86.3 хувь буюу 17.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Үүнд: Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, бууны албан татвар, малын тоо толгойн албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого тасарсан нь нөлөөлсөн байна.
- Батширээт сумын татварын орлогын гүйцэтгэл 355.9 хувиар давж биелсэн нь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 17.5 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 48.8 сая төгрөг, малын тоо толгойн албан татвар 44.0 сая төгрөг, ойн нөөц ашигласны төлбөр 650.9 сая төгрөгөөр тус тус давж биелсэн нь нөлөөлсөн байна.
- Өмнөдэлгэр сумын татварын орлогын гүйцэтгэл 246.2 хувиар давж биелсэн нь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 25.4 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 46.3 сая төгрөг, малын тоо толгойн албан татвар 9.6 сая төгрөг, газрын төлбөр 30.7 сая төгрөг, ойн нөөц ашигласны төлбөр 606.3 сая төгрөгөөр тус тус давж биелсэн нь нөлөөлсөн байна.
- Баян-Овоо сумын татварын орлогын гүйцэтгэл 231.6 хувиар давж биелсэн нь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 18.7 сая төгрөг, малын тоо толгойн албан татвар 95.9 сая төгрөг, газрын төлбөр 32.8 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 126.5 сая төгрөгөөр тус тус давж биелсэн нь нөлөөлсөн байна.
- Татварын нэр төрлөөр авч үзвэл хөрөнгийн орлого 89.5 хувь, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 88.1 хувь буюу биелэлттэй байна. Хөрөнгийн

орлогын биелэлтэд иргэдийн банкин дахь хадгаламжийн хэмжээ буурсантай холбоотой, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогын биелэлтэд тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж цөөхөн байгаагаас шалтгаалсан тус тус тасарсан байна.

Орлогыг нэр төрлөөр авч үзвэл:

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, үйл ажиллагааны орлого, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого, урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагналын орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, бууны албан татвар, малд ноогдуулах албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, хог хаягдлын үйлчилгээний хураамж, газрын төлбөр, ойн нөөц ашигласан, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөр, торгуулийн орлого нийт 4,342.2 сая төгрөгөөр давж биелсэн, хөрөнгийн орлого, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр, бусад орлогууд нэр төрлөөрөө тасарсан үзүүлэлттэй байна.

- Ойн нөөц ашигласны төлбөрийг Батширээт сум 650.9 сая төгрөг, Өмнөдэлгэр сум 606.3 сая төгрөгөөр биелсэн нь самар түүж, худалдах борлуулах зөвшөөрөл олгосноос, Дадал сум 23.8 сая төгрөг, Норовлин сум 15.8 сая төгрөгөөр биелүүлсэн нь ойн цэвэрлэгээний гоожингийн үнэ орсноор тус тус давж биелжээ.
- Агнуурын нөөц ашигласны төлбөрийг Баянхутаг сум 189.5 сая төгрөг, Баянмөнх 33.7 сая төгрөг, Дэлгэрхаан сум 247.0 сая төгрөг, Жаргалтхаан сум 39.2 сая төгрөг, Норовлин сум 65.0 сая төгрөг, Батноров сум 157.1 сая төгрөг, Баян-Овоо сум 126.5 сая төгрөг, Мөрөн сум 72.9 сая төгрөг, Хэрлэн 65.2 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн нь нэг удаагийн шинж чанартай ангийн орлого орсонтой холбоотой байна.
- Малын тоо толгойн албан татварын орлогыг төлөвлөөгүй Батширээт сум 44.0 сая төгрөг, Дадал сум 35.7 сая төгрөг, Норовлин сум 73.6 сая төгрөг, Баян-Овоо сум 95.9 сая төгрөг нийт 249.2 төгрөгийн орлого орсон байна.

Дараах орлого тасарсан байна. Үүнд:

- Хөрөнгийн орлогыг Галшар сум 2.0 сая төгрөг, Баянхутаг сум 10.6 сая төгрөг, Баянмөнх сум 5.5 сая төгрөг, Дархан сум 7.2 сая төгрөг, Жаргалтхаан сум 7.1 сая төгрөг, Цэнхэрмандал сум 2.2 сая төгрөг, Өмнөдэлгэр сум 12.4 сая төгрөг, Батширээт сум 2.2 сая төгрөг, Баян-Адарга сум 6.0 сая төгрөг, Дадал сум 5.0 сая төгрөг, Баян-Овоо сум 5.0 сая төгрөг, Мөрөн сум 1.1 сая төгрөг, Хэрлэн сум 34.9 сая төгрөг, Гурванбаян тосгон 0.1 сая төгрөг, Өлзийт тосгон 2.1 сая төгрөг, Бор-Өндөр сум 41.2 сая төгрөг, Бэрх тосгон 7.8 сая төгрөгөөр тус тус тасарсан нь суманд иргэдийн хадгаламж буурсантай холбоотой байна.
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашигласны төлбөрийн орлогыг Баянмөнх сум 2.3 сая төгрөг, Жаргалтхаан 0.7 сая төгрөг, Цэнхэрмандал сум 0.7 сая төгрөг, Баян-Овоо сум 1.1 сая төгрөг, Мөрөн сум 7.0 сая төгрөг, Хэрлэн сум 30.2 сая төгрөг төгрөгөөр тус тус тасарсан нь тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж сумдад байдаггүйгээс шалтгаалсан байна.
- Бусад орлогыг Баянхутаг сум 8.6 сая төгрөг, Баянмөнх сум 2.3 сая төгрөг, Дархан сум 25.3 сая төгрөг, Дэлгэрхаан сум 24.3 сая төгрөг, Цэнхэрмандал сум 44.9 сая төгрөг, Батширээт сум 6.9 сая төгрөг, Батноров сум 37.0 сая төгрөг, Баян-Овоо сум 1.5 сая

төгрөг, Өлзийт тосгон 0.9 сая төгрөг, Бор-Өндөр сум 58.5 сая төгрөгөөр тус тус тасарсан нь орлогын төлөвлөлтийг үндэслэлгүй төлөвлөснөөс шалтгаалсан байна.

**Илрүүлэлт:**

ОНХС-д малын тоо толгойн албан татварыг Батширээт сум 30.9 сая төгрөгөөр, Өлзийт тосгон 1.4 сая төгрөгөөр, түрээсийн орлогыг Бор-Өндөр сумын хот тохижилт ТБАГУТҮГ 0.2 сая төгрөгөөр, хайрганы орлогыг Хэнтий-Ус ХХК 2.0 сая төгрөгөөр, хувь хүнээс суутган тооцсон татварыг 0.6 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн.

**Шийдвэрлэлт:** Дутуу төвлөрүүлсэн малын тоо толгойн албан татвар, түрээсийн орлого, хайрганы орлогыг төвлөрүүлэх 5 төлбөрийн акт тогтоосон.

Сумын татварын орлогын төлөвлөгөөг Галшар сум 20.1 сая төгрөгөөр, Цэнхэрмандал сум 11.4 сая төгрөгөөр тасалсан.

**Шийдвэрлэлт:** Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага өгсөн.

Дэлгэрхаан сум торгуулийн орлого, рашаан ус ашигласны төлбөрийг 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, ҮХЭХАТ-ын гүйцэтгэлийг 0.5 сая төгрөгөөр, торгуулийн орлогын гүйцэтгэлийг 2.5 сая төгрөгөөр залруулахдаа зардалд бичсэн, 9.0 сая төгрөгийн бусад орлогыг татварын орлогын нэр төрлийн дансаар дамжуулаагүй шууд хаалтын дансанд бүртгэсэн, Хэрлэнбаян-Улаан тосгон торгуулийн орлогын гүйцэтгэлийг 0.2 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн.

**Шийдвэрлэлт:** Орлогыг зардалд хааж бичсэн зөрчлийг таслан зогсоох 3 албан шаардлага хүргүүлсэн байна.

**1.3 Байгаль хамгаалах, Хоршоо хөгжүүлэх, Орон нутгийн хөгжлийн сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 471.9 сая төгрөгөөр өссөн байна.**

**1.3.1 Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 104.7 хувь буюу 418.5 сая төгрөгөөр давж биелсэн нь малын тоо толгойн албан татварын төвлөрүүлэлтээс шалтгаалсан байна.**

Орон нутгийн хөгжлийн сангийн нийт эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 7,856.3 сая төгрөг, малын тоо толгойн албан татвараас 1,000.9 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 2,623.7 сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр 73.0 сая төгрөг нийт 11,553.8 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 9,348.5 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

Хүснэгт №4

/сая төгрөгөөр/

д/д	Сумдын нэр	Орлого			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Зөрүү
А	1	2	3	4=3/2	5=3-2
1	Баян-Адарга	191.9	192.6	100.3	0.7
2	Баянмөнх	85.7	149.4	174.4	63.7
3	Батноров	322.8	243.6	75.5	(79.2)
4	Баян-Овоо	145.9	209.6	143.7	63.7
5	Баянхутаг	123.2	146.7	119.1	23.5
6	Батширээт	208.0	208.0	100.0	-

7	Бэрх	74.1	121.8	164.4	47.7
8	Бор-Өндөр	408.8	419.2	102.5	10.4
9	Галшар	255.6	236.9	92.7	(18.7)
10	Гурванбаян	43.4	57.8	133.1	14.4
11	Дархан	254.5	240.3	94.4	(14.2)
12	Дадал	270.7	274.7	101.5	3.9
13	Дэлгэрхаан	85.8	120.1	139.8	34.2
14	Жаргалтхаан	219.1	219.1	100.0	0.0
15	Мөрөн	114.9	138.2	120.3	23.3
16	Норовлин	198.9	245.1	123.2	46.1
17	Хэрлэн баян улаан	34.5	36.9	107.1	2.4
18	Хэрлэн	437.7	473.3	108.1	35.6
19	Цэнхэрмандал	229.7	232.5	101.2	2.8
20	Өмнөдэлгэр	357.3	497.7	139.3	140.4
21	Өлзийт	58.8	59.7	101.6	0.9
22	Биндэр	235.0	251.7	107.1	16.7
23	Хот тохижилт	158.3	158.3	100.0	-
24	Мал эмнэлэг	409.8	409.8	100.0	-
25	Усны татаас	11.5	11.5	100.0	-
26	Аймгийн ОНХС	3,994.3	3,994.3	100.0	-
	<b>Дүн</b>	<b>8,930.2</b>	<b>9,348.5</b>	<b>104.7</b>	<b>418.4</b>

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 104.7 хувь буюу 418.5 сая төгрөгөөр давж биелсэн нь малын тоо толгойн албан татварын төвлөрүүлэлтээс шалтгаалсан байна.

Аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих төлөвлөгөөг 18.0 сая төгрөгөөр илүү тусгасан байна.

**1.3.2 Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө 3,077.6 сая төгрөгөөр тасарсан нь зээлийн авлагын үлдэгдлийн 53.3 хувь 5-аас дээш жилээр хугацаа хэтэрсэнтэй холбоотой байна.**

Хоршоо хөгжүүлэх сангийн орлогыг 4,080.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,003.2 сая төгрөгийг төвлөрүүлж 3,077.6 сая төгрөг буюу 75.4 хувиар тасарсан байна.

#### Хоршоо хөгжүүлэх сангийн төлөвлөлт, гүйцэтгэл, үлдэгдэл

Хүснэгт №5

/сая төгрөгөөр/

№	Сум	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Орлого			Зарлага	Эцсийн үлдэгдэл
					Эхний үлдэгдэл	Зээлийн төлөлт	Шилжиж ирсэн		
А	1	2	3	4=3-2	5	6	7	8	9=5+6+7-8
1	Баян-Адарга	98.5	38.3	(60.2)	21.4	38.3	33.8	0.1	93.5
2	Биндэр	161.7	27.5	(134.1)	80.3	27.5	27.9	0.1	135.6
3	Баянмөнх	120.6	30.3	(90.4)	38.0	30.3	53.2	-	121.5
4	Батноров	183.8	49.5	(134.3)	48.3	49.5	55.5	0.5	152.7
5	Баян-Овоо	167.6	17.1	(150.5)	102.1	17.1	33.2	30.1	122.3
6	Баянхутаг	59.2	1.0	(58.2)	14.9	1.0	14.8	-	30.7
7	Батширээт	112.4	39.0	(73.5)	47.8	39.0	2.9	0.1	89.6
8	Бэрх	180.0	31.8	(148.2)	39.4	31.8	72.1	-	143.3
9	Бор-Өндөр	629.1	122.7	(506.4)	183.3	122.7	24.0	0.1	329.9
10	Галшар	189.9	50.8	(139.1)	92.4	50.8	47.6	0.1	190.7
11	Гурванбаян	20.8	2.3	(18.4)	14.4	2.3	-	-	16.7
12	Дархан	295.9	63.9	(231.9)	116.7	63.9	64.8	90.2	155.3
13	Дадал	115.6	67.1	(48.5)	2.4	67.1	45.8	114.6	0.7
14	Дэлгэрхаан	85.3	14.0	(71.3)	20.8	14.0	19.6	-	54.4
15	Жаргалтхаан	164.6	24.0	(140.6)	89.2	24.0	11.4	1.1	123.5
16	Мөрөн	161.5	24.9	(136.5)	55.4	24.9	24.8	0.1	104.9
17	Норовлин	170.7	17.4	(153.4)	80.3	17.4	5.9	0.1	103.4
18	Хэрлэн баян улаан	9.9	-	(9.9)	7.9	-	-	-	7.9
19	Хэрлэн	788.8	349.9	(438.9)	230.7	349.9	52.7	412.2	221.1
20	Цэнхэрмандал	179.5	12.7	(166.8)	90.5	12.7	49.5	-	152.7
21	Өмнөдэлгэр	185.0	18.7	(166.3)	115.6	18.7	39.4	129.3	44.5
22	Өлзийт	0.5	0.3	(0.2)	5.4	0.3	-	-	5.7
	<b>Дүн</b>	<b>4,080.8</b>	<b>1,003.2</b>	<b>(3,077.6)</b>	<b>1,497.2</b>	<b>1,003.2</b>	<b>678.8</b>	<b>778.7</b>	<b>2,400.6</b>

Зээлийн үлдэгдлийн 5,416.6 сая төгрөгөөс 1,953.2 сая төгрөгийн зээл хугацаандаа 576.3 сая төгрөгийн зээл 5 хүртэлх жил, 2,887.1 сая төгрөгийн зээл 5-аас дээш жилээр хугацаа хэтэрсэн байна.

### 1.3.3 Байгаль хамгаалах сангийн орлогод зориулалт бус орлого төвлөрүүлдэг зөрчил нийтлэг байна.

Байгаль хамгаалах сангийн орлогыг 210.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 93.3 сая төгрөгийг төвлөрүүлж 117.1 сая төгрөг буюу 55.7 хувиар тасарсан байна.

#### Байгаль хамгаалах сангийн төлөвлөлт, гүйцэтгэл, үлдэгдэл

Хүснэгт №6		/сая төгрөгөөр/						
№	Сум	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
А	1	2	3	4=3-2	5	6	8	9=5+6+7-8
1	Баян-Адарга	24.9	2.0	(22.9)	24.9	2.0	-	26.9
2	Биндэр	10.0	7.3	(2.7)	1.9	7.3	9.1	0.1
3	Баянмөнх	0.5	-	(0.5)	0.5	-	-	0.5
4	Батноров	69.7	58.1	(11.7)	64.7	58.1	-	122.8
5	Баян-Овоо	3.5	0.9	(2.6)	3.5	0.9	3.5	0.9
6	Баянхутаг	2.3	-	(2.3)	0.8	-	0.2	0.6
7	Батширээт	-	0.3	0.3	0.8	0.3	-	1.0
8	Бор-Өндөр	1.2	-	(1.2)	-	-	-	-
9	Галшар	12.2	0.5	(11.7)	11.7	0.5	11.7	0.5
10	Дархан	13.0	0.7	(12.3)	14.1	0.7	-	14.8
11	Дадал	2.5	-	(2.5)	2.3	-	2.3	-
12	Дэлгэрхаан	9.0	-	(9.0)	9.0	-	9.0	0.0
13	Жаргалтхаан	15.6	1.8	(13.8)	8.6	1.8	8.5	1.9
14	Мөрөн	2.7	1.1	(1.7)	0.1	1.1	1.0	0.1
16	Хэрлэн	25.7	2.4	(23.3)	25.7	2.4	9.0	19.1
17	Цэнхэрмандал	15.9	15.4	(0.5)	6.4	15.4	12.0	9.8
18	Өмнөдэлгэр	1.7	3.0	1.3	1.7	3.0	0.6	4.1
	<b>Дүн</b>	<b>210.4</b>	<b>93.3</b>	<b>(117.1)</b>	<b>176.7</b>	<b>93.3</b>	<b>66.8</b>	<b>203.2</b>

Сангийн орлогын төлөвлөгөөг Өмнөдэлгэр сум 180.0 хувь биелүүлж, Баянмөнх, Баянхутаг, Бор-Өндөр, Дадал, Дэлгэрхаан сумд биелүүлээгүй, бусад сум 3.3 хувиас 95.9 хувиар тасалсан байна.

#### Илрүүлэлт:

Тайлант оны эцэст Батноров, Батширээт, Баян-Адарга, Баянмөнх, Баянхутаг, Биндэр, Дархан, Өмнөдэлгэр, Хэрлэн, Цэнхэрмандал сумд байгаль хамгаалах сангийн үлдэгдэл 193.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй.

Шийдвэрлэлт: Байгаль хамгаалах сангийн үлдэгдлийг харьяа сумын төсөвт төвлөрүүлэх 10 төлбөрийн акт тогтоов.

Биндэр сумын байгаль хамгаалах сангийн дансанд 7.2 сая төгрөгийн ойд учруулсан нөхөн төлбөр, торгуулийн орлогыг төвлөрүүлсэн.

Шийдвэрлэлт: Татварын орлогыг буруу төвлөрүүлсэн зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага өгсөн.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Байгаль хамгаалах сангийн орлогод зориулалт бус орлого төвлөрүүлж зориулалтын бус зарцуулдаг, сангийн зарцуулагдаагүй удаан хугацаагаар байршуулсан үлдэгдлийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлээгүй зэрэг зөрчил нийтлэг илэрсэн байна. Иймд Байгаль хамгаалах санг

барьцаа хөрөнгийн данс хэлбэрээр ашиглаж байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээг төсөв захирагчийн холбогдох арга хэмжээнд төлөвлөж хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Байгаль хамгаалах сангийн орлогын гүйцэтгэл 44.3 хувь, Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын гүйцэтгэл 24.6 хувь байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд сангийн орлогын төлөвлөлтийг үндэслэлтэй хийх, батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж төсвийн хэрэгжилтийн талаар хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллах шаардлагатай байна.

### Сангуудын үлдэгдлийн судалгаа

Хүснэгт №7					/сая төгрөгөөр/
№	Сангийн нэр	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Орон нутгийн хөгжлийн сан	2,911.0	9,350.1	9,808.0	2,453.1
2	Байгаль хамгаалах сан	176.7	93.3	66.8	203.2
3	Хоршоо хөгжүүлэх сан	1,497.2	1,682.0	778.7	2,400.5
	<b>Нийт</b>	<b>4,584.9</b>	<b>11,125.4</b>	<b>10,653.5</b>	<b>5,056.8</b>

Байгаль хамгаалах, Хоршоо хөгжүүлэх, Орон нутгийн хөгжлийн сангуудын мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 5,056.8 сая төгрөг болж өмнөх оноос 471.9 сая төгрөгөөр өссөн байна. Иймд сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байнга өсөх хандлагатай байгааг анхаарч төсвийн төлөвлөлт хийхдээ бодлого чиглэл боловсруулсан сангуудын үлдэгдлийг дайчлан эргэлтэд оруулах, мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлж сангийн үр өгөөжийг сайжруулах шаардлагатай байна.

### ХОЁР. НИЙТ ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ 84.6 ХУВЬТАЙ БАЙНА.

**2.1 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын хэмнэлт 1,634.0 сая төгрөгөөс 744.2 сая төгрөгийн хэмнэлт нь үндэслэлгүй төлөвлөлттэй холбоотой байна.**

Хэнтий аймгийн 2022 оны төсвийн нийт зарлага тодотгосон төсвөөр 63,761.4 сая төгрөгөөр батлагдсанаас 53,952.1 сая төгрөгийг зарцуулж, 84.6 хувь буюу 9,809.3 сая төгрөг гүйцэтгэлээр хэмнэгдсэн байна. Өмнөх оны зарлагын гүйцэтгэлээс 37.9 хувиар буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд улсын төсөвт шилжсэнтэй холбоотой байна. Төсвийн хэмнэлт 9,976.6 сая төгрөгийн 7,735.3 сая төгрөг нь Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, 697.3 сая төгрөг нь Соёл урлаг, 614.6 сая төгрөг нь Ерөнхий боловсрол арга хэмжээнээс хэмнэгдсэн байна.

### Төсвийн гүйцэтгэл, арга хэмжээний ангиллаар

Хүснэгт №8					/сая төгрөгөөр/
№	Хөтөлбөрийн нэр	Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Дүнд эзлэх хувь
1	ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	3,058.99	2,899.49	159.50	1.6%
2	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	31,603.89	25,806.80	5,797.08	59.1%
3	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	168.26	161.39	6.87	0.1%
4	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	125.30	124.74	0.56	0.0%
5	ОН-ын төсөвт олгох орлогын шилжүүлэг	11,413.47	9,649.66	1,763.81	18.0%
6	Мал аж ахуйг хөгжүүлэх	153.04	153.04	-	0.0%
7	Авто зам	900.00	838.33	61.67	0.6%
8	Авто тээврийн хяналт, зохицуулалт	20.00	7.09	12.91	0.1%
9	Ойжуулалт	259.64	250.50	9.14	0.1%

10	Байгал орчин хамгаалан нөхөн сэргээх	1,376.32	1,152.96	223.37	2.3%
11	Хот байгуулалт, тохижилт	1,855.78	1,797.42	58.36	0.6%
12	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	769.90	644.30	125.59	1.3%
13	Биеийн тамир спорт	292.46	292.12	0.34	0.0%
14	Соёл урлаг	2,016.51	1,319.20	697.31	7.1%
15	Сургуулийн өмнөх боловсрол	2,551.65	2,344.86	206.79	2.1%
16	Ерөнхий боловсрол	6,179.08	5,564.47	614.62	6.3%
17	Мэргэжлийн боловсрол	768.72	745.03	23.69	0.2%
18	Насан туршийн болон албан бус боловсрол	15.04	14.49	0.55	0.0%
19	Нийгмийн халамж	152.73	105.56	47.17	0.5%
20	Хүүхдийн хөгжил, хамгаалал	80.66	80.66	-	0.0%
<b>Нийт дүн</b>		<b>63,761.45</b>	<b>53,952.12</b>	<b>9,809.33</b>	<b>100%</b>

Төсвийн гүйцэтгэлийг арга хэмжээний ангиллаар авч үзвэл нийт гүйцэтгэлийн 59.1 хувийг Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, 18.0 хувийг орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, 7.1 хувийг Соёл урлаг, 6.3 хувийг Ерөнхий боловсрол, 2.3 хувийг Байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх, 1.6 хувийг Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны арга хэмжээ эзэлж байгаа бол бусад 14 арга хэмжээнд 5.6 хувь зарцуулагдсан байна.

Төсвийн гүйцэтгэл, эдийн засгийн ангиллаар


Хүснэгт №9

/сая төгрөгөөр/

Хөтөлбөрийн нэр	Өмнөх оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Гүйцэтгэл хувь	Дүнд эзлэх хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>86,864.7</b>	<b>63,761.4</b>	<b>53,952.1</b>	<b>9,809.4</b>	<b>84.6</b>	<b>100.0</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	73,070.7	38,122.9	34,236.1	3,886.8	89.8	63.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,144.9	35,467.8	31,760.6	3,707.1	89.6	58.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,931.5	10,487.0	9,650.5	836.6	92.0	17.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,486.2	1,322.7	1,212.9	109.9	91.7	2.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,868.4	11,313.4	9,679.4	1,634.0	85.6	17.9
Хангамж, бараа материалын зардал	1,746.5	876.3	823.6	52.7	94.0	1.5
Норматив зардал	2,028.2	185.3	184.2	1.0	99.4	0.3
Эд хогшил, урсгал засварын зардал	2,181.7	1,471.4	1,436.3	35.1	97.6	2.7
Томилолт, зочны зардал	242.1	232.2	224.0	8.1	96.5	0.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,105.2	5,576.3	5,031.4	544.9	90.2	9.3
Бараа үйлчилгээний бусад зардал	5,555.1	4,003.1	3,518.3	484.8	87.9	6.5
ХҮҮ		<b>344.4</b>	<b>344.4</b>	-	<b>100.0</b>	<b>0.6</b>
ТАТААС	284.2	<b>388.7</b>	<b>287.1</b>	<b>101.6</b>	<b>73.9</b>	<b>0.5</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	40.2	20.0	7.1	12.9	35.5	0.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	244.0	368.7	280.0	88.7	75.9	0.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<b>1,641.6</b>	<b>1,922.0</b>	<b>1,844.0</b>	<b>78.0</b>	<b>95.9</b>	<b>3.4</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	176.6	840.3	829.0	11.3	98.7	1.5
Бусад урсгал шилжүүлэг	1,465.0	1,081.7	1,015.0	66.7	93.8	1.9
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>12,870.2</b>	<b>21,620.7</b>	<b>18,952.7</b>	<b>2,668.0</b>	<b>87.7</b>	<b>35.1</b>
Барилга байгууламж	1,850.0					-
Их засвар	-	4,040.3	4,410.8	(370.5)	109.2	8.2
Тоног төхөөрөмж		42.0	35.9	6.1	85.5	0.1
Бусад хөрөнгө	11,020.2	17,538.5	14,506.1	3,032.4	82.7	26.9
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>923.8</b>	<b>4,017.9</b>	<b>763.3</b>	<b>3,254.6</b>	<b>19.0</b>	<b>1.4</b>

Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийн 63.5 хувийг урсгал зардал, 35.1 хувийг хөрөнгийн зардал, 1.4 хувийг эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл эзэлж байна.

Орон нутгийн төсвийн нийт зардлын 2021-2022 оны гүйцэтгэл. График №1



Дээрх графикаас харахад өмнөх оноос байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,811.0 сая төгрөг, хөрөнгийн зардал 6,082.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 926.1 сая төгрөг, хүүгийн зардал 344.4 сая төгрөг, урсгал шилжүүлэг 202.5 сая төгрөгөөр тус тус өссөн бол цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 36,554.8 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 745.4 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 922.9 сая төгрөг, нормативт зардал 1,844.1 сая төгрөг, томилолт зочны зардал 18.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 2,036.8 сая төгрөг, эргэн төлөгдөх цэвэр зээл 160.5 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Энэ нь тайлант онд гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлснээс шалтгаалсан байна.

*Хөрөнгийн зардлын талаар:*

Хөрөнгийн зардлын гүйцэтгэл 18,952.7 сая төгрөг болж өмнөх оноос 6,082.5 сая төгрөгөөр буюу 147.3 хувиар өссөн байна. Дээрх өсөлтөд Хэнтий аймгийн Засаг дарга 5,150.8 сая төгрөг, Батширээт сум 451.2 сая төгрөг, Өмнөдэлгэр сум 336.0 сая төгрөг, Дархан сум 287.7 сая төгрөг, Цэнхэрмандал сум 178.9 сая төгрөг, Дэлгэрхаан сум 161.1 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Харин Галшар сум 345.7 сая төгрөг, Хэрлэн сум 375.4 сая төгрөг, Бор-Өндөр сум 361.2 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Хөрөнгийн зардлын гүйцэтгэл байгууллагаар

Хүснэгт №10

/сая төгрөгөөр/

№	Сумд	Өмнөх оны гүйцэтгэл	2022 оны гүйцэтгэл					Зөрүү
			ЗДТГ	Ойн анги	ОН-ын хөрөнгө оруулалт	ОНХС	Нийт	
1	Засаг дарга	7,576.1	-	-	8,169.7	4,557.1	12,726.8	5,150.74
2	Галшар	620.1	0.5	-	-	273.9	274.4	(345.71)
3	Баянхутаг	112.6	-	-	-	196.0	196.0	83.44
4	Баянмөнх	104.2	-	-	-	115.3	115.3	11.08
5	Дархан	277.9	-	-	-	565.6	565.6	287.71
6	Дэлгэрхаан	62.5	68.5	-	-	155.1	223.7	161.14

7	Жаргалтхаан	352.9	167.8	-	-	263.4	431.2	78.29	
8	Цэнхэрмандал	191.0	129.0	-	-	240.9	369.9	178.89	
9	Өмнөдэлгэр	438.7	319.5	-	-	455.2	774.6	335.95	
10	Батширээт	121.2	195.7	40.0	-	336.7	572.4	451.24	
11	Биндэр	213.2	32.7	-	-	229.2	261.9	48.72	
12	Баян-Адарга	158.7	-	-	-	135.6	135.6	(23.02)	
13	Дадал	120.4	-	-	-	196.2	196.2	75.79	
14	Норовлин	157.4	-	-	-	204.2	204.2	46.78	
15	Батноров	280.7	10.0	-	-	336.8	346.8	66.14	
16	Баян-Овоо	169.1	58.0	-	-	239.3	297.3	128.17	
17	Мөрөн	82.2	-	-	-	114.4	114.4	32.23	
18	Хэрлэн	736.0	25.7	-	-	334.9	360.6	(375.36)	
19	Гурванбаян	49.5	-	-	-	45.5	45.5	(4.07)	
20	Хэрлэнбаян улаан	9.7	-	-	-	38.0	38.0	28.30	
21	Өлзийт	40.0	-	-	-	76.5	76.5	36.55	
22	Бор-Өндөр	906.6	91.0	-	-	454.4	545.4	(361.18)	
23	Бэрх	89.4	-	-	-	80.1	80.1	(9.30)	
	<b>Нийт дүн</b>	<b>12,870.2</b>	<b>1,098.4</b>	<b>40.0</b>		<b>8,169.7</b>	<b>9,644.6</b>	<b>18,952.7</b>	<b>6,082.53</b>

Нийт хөрөнгийн зардлын 50.9 хувийг ОНХС, 43.1 хувийг Орон нутгийн хөрөнгө оруулалт, 5.8 хувийг сумдын хөрөнгө оруулалт, 0.2 хувийг ойн ангийн хөрөнгийн зардал эзэлж байна.

#### Хөрөнгийн зардлын гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар

##### Хүснэгт №11

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Барилга байгууламж	Их засвар	Тоног		Бусад хөрөнгө			Нийт
			төхөөрөмж	Ойн анги	ЗДТГ	ОНХО	ОНХС	
2021 он	1,850.00				945.65	1,097.25	8,977.31	12,870.21
2022 он		4,011.33	35.87	40.00	1,062.56	4,158.40	9,644.57	18,952.74
<b>Зөрүү</b>	<b>(1,850.00)</b>	<b>4,011.33</b>	<b>35.87</b>	<b>40.00</b>	<b>116.91</b>	<b>3,061.15</b>	<b>667.26</b>	<b>6,082.53</b>
<b>Хувь</b>					112.36	378.98	107.43	147.26

Хөрөнгийн нийт зардлыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл их засвар 4,011.3 сая төгрөг, тоног төхөөрөмж 35.9 сая төгрөг, бусад хөрөнгө 14,905.5 сая төгрөг байна.

Бусад хөрөнгөд Батширээт сум дундын ойн анги 40.0 сая төгрөг, сумдын хөрөнгийн зардал 1,062.6 сая төгрөг, Орон нутгийн хөрөнгө оруулалт 4,158.4 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 9,644.6 сая төгрөг байна.

Сумдын хөрөнгийн зардал өмнөх оноос 116.9 сая төгрөг, Орон нутгийн хөрөнгө оруулалт 3,061.2 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 667.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Өмнөх онд 30 төсөл арга хэмжээнд 1,546.5 сая төгрөг баталж 1,097.3 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан бол тайланд онд орон нутгийн хөрөнгө оруулалтын 20 төсөл арга хэмжээнд 4,731.0 сая төгрөг, их засварын 12 төсөл арга хэмжээнд 4,040.3 сая төгрөгийн төсөв баталж 8,169.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Төсөл арга хэмжээний тоо өмнөх оноос 33.3 хувиар буурсан боловч хөрөнгө оруулалтын зардал 7.6 дахин өссөн байна.

Тайланд онд 325.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд:

- ✓ 410.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөдөө аж ахуйн хөгжлийн төвийн засвар, тохижилт арга хэмжээнд 205.0 сая төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч тендер зарлаад гүйцэтгэгч шалгараагүй
- ✓ 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Биндэр сумын цанын баазын зураг төсөл арга хэмжээний гэрээ байгуулсан боловч гүйцэтгэл гараагүй

- ✓ 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хэрлэн соёл амралтын хүрээлэнгийн зураг төсөл арга хэмжээнд 5 сараас тендер шалгаруулалт хийж 11 сард гэрээ байгуулсан боловч ондоо багтаж хэрэгжихээргүй болсон тул санхүүжилт олгоогүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд их засварыг 399.4 сая төгрөгөөр илүү, хөрөнгө оруулалтыг 399.4 сая төгрөгөөр дутуу илэрхийлснийг аудитын явцад залруулав.

*Байр ашиглалтай холбоотой тогтмол зардлын талаар:*

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын гүйцэтгэл 9,679.4 сая төгрөг болж өмнөх оноос 1,811.0 сая төгрөгөөр буюу 123.0 хувиар өссөн байна. Дээрх өсөлтийг эдийн засгийн ангиллаар авч үзвэл гэрэл цахилгааны зардал 250.5 сая төгрөг буюу 40.7 хувиар, түлш халаалтын зардал 1,443.7 сая төгрөг буюу 20.8 хувиар, цэвэр бохир усны зардал 112.1 сая төгрөгөөр буюу 42.1 хувиар, байрны түрээсийн зардал 4.8 сая төгрөгөөр буюу 11.1 хувиар тус тус өссөн байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 11,313.5 сая төгрөгийн төсөв баталж 9,679.4 сая төгрөгийг зарцуулж, 1,634.0 сая төгрөг буюу 85.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын хэмнэлтээс 330.0 сая төгрөгийг урсгал засварын зардалд шилжүүлэн зохицуулалт хийн зарцуулсан байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ыг баримтлаагүйгээс шалтгаалсан байна.

Хэмнэгдсэн зардлын 1,634.0 сая төгрөгийн 889.8 сая төгрөг нь шинээр ашиглалтад орох болон өргөтгөл хийгдсэн барилгатай холбогдуулан төлөвлөсөн, 744.2 сая төгрөг нь үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой байна.

## **2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт малын тоо толгойн албан татварын орлогоос үүссэн эх үүсвэрийг бүрэн төлөвлөхгүй байна.**

Орон нутгийн хөгжлийн сангийн зарлагын төлөвлөгөөг 11,553.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 9,808.0 сая төгрөгийг зарцуулж, биелэлт 84.9 хувь байна.

### Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл

Хүснэгт №12

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Аймгийн ОНХС	Сумдын ОНХС	Хот		Усны татаас	Нийт
			тохижилтын үйлчилгээ	Мал эмнэлгийн үйлчилгээ		
<b>Гүйцэтгэл</b>	4,135.8	5,092.6	158.3	409.8	11.5	9,808.0
<b>Хувь</b>	42.2	51.9	1.6	4.2	0.1	100.0

Орон нутгийн хөгжлийн сангийн 42.2 хувь аймагт, 51.9 хувь сумдад, 1.6 хувь хот тохижилтын үйлчилгээнд, 4.2 хувь мал эмнэлгийн үйлчилгээнд тус тус зарцуулагдсан байна.

Тайлант онд аймгийн ОНХС-д 44 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,494.1 сая төгрөгийн төсөв баталж 4,135.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

## Аймгийн ОНХС-ын төсөл арга хэмжээ

Хүснэгт №13

/сая төгрөгөөр/

№	ОНХС-ын хэрэгжүүлэх арга хэмжээний заалт	Төсөл арга хэмжээний тоо	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	4.2.1	16	794.9	781.8	13.1	98.4
2	4.2.2	12	1,865.1	1,768.1	96.9	94.8
3	4.2.3	7	1,169.3	1,098.0	71.3	93.9
4	4.2.4	1	65.0	-	65.0	-
5	4.2.5	6	471.5	389.7	81.8	82.6
6	4.2.6	1	100.0	69.8	30.2	69.8
7	4.2.7	1	28.3	28.3	-	100.0
		44	4,494.1	4,135.8	358.3	92.0

Аймгийн ОНХС-ын 2022 онд хэрэгжүүлсэн 44 арга хэмжээний 36.4 хувь нь иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёлын үйл ажиллагаанд, 27.3 хувь нь дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, цахилгаан, дулааны шугам сүлжээний ажилд, 15.9 хувь нь орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд, 13.6 хувь нь аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, зураг төсөв боловсруулах үйл ажиллагаанд тус тус зарцуулагдсан байна.

Тайлант онд 136.8 сая төгрөгийн дараах төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

- ✓ 2-р багийн худаг, цэвэр усны шугам, ухаалаг систем /Хэрлэн сум / 65.0 сая төгрөг
- ✓ 2-р хэлхээний шугам сүлжээний зураг төсөл 30.0 сая төгрөг
- ✓ Аялал жуулчлалын маршрутын дагуу түр буудаллах цэг зураг төсөл 5.6 сая төгрөг
- ✓ Дулааны станцын ус хангамж ариутгал татуургын зураг төсөл 36.2 сая төгрөг

Тайлант онд сумдын ОНХС-д 213 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,473.5 сая төгрөгийн төсөв баталж 5,092.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

## Аймгийн ОНХС-ын төсөл арга хэмжээ

Хүснэгт №14

/сая төгрөгөөр/

№	ОНХС-ын хэрэгжүүлэх арга хэмжээний заалт	Төсөл арга хэмжээний тоо	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлд эзлэх хувь
1	4.2.2	5	184.3	183.9	0.46	3.61
2	4.2.3	2	158.1	156.7	1.41	3.08
3	4.4.1	26	731.5	516.8	214.71	10.15
4	4.4.2	20	938.4	900.2	38.17	17.68
5	4.4.3	47	1,905.8	1,546.9	358.90	30.38
6	4.4.4	19	626.3	323.9	302.46	6.36
7	4.4.5	2	41.0	43.6	(2.60)	0.86
8	4.4.6	4	122.7	80.7	42.09	1.58
9	4.4.9	4	70.0	67.5	2.50	1.32
10	4.5.1	4	42.0	28.9	13.09	0.57
11	4.5.10	2	19.0	19.0	-	0.37
12	4.5.11	7	53.3	55.9	(2.64)	1.10
13	4.5.12	8	36.1	28.9	7.16	0.57
14	4.5.2	19	336.7	276.4	60.24	5.43
15	4.5.3	12	372.7	141.7	230.97	2.78
16	4.5.4	11	300.6	287.3	13.27	5.64
17	4.5.5	6	92.6	28.0	64.60	0.55
18	4.5.6	4	61.3	56.5	4.84	1.11
19	4.5.8	7	271.3	240.1	31.19	4.72
20	4.5.9	4	109.8	109.7	0.13	2.15
	<b>Нийт</b>	<b>213</b>	<b>6473.5</b>	<b>5092.6</b>	<b>1380.9</b>	<b>100</b>

Сумын ОНХС нь нийт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 61.5 хувийг дараах 5 чиглэлд зарцуулсан байна.

- ✓ Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;
- ✓ Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;
- ✓ Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах;
- ✓ Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;
- ✓ Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;/хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах/

Сумын ОНХС-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 213 төсөл арга хэмжээнээс 922.9 сая төгрөгийн 35 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Тендер шалгаруулалтыг зохион байгуулсан боловч санал ирүүлээгүй, журамд нийцээгүй арга хэмжээ төлөвлөсөн, худалдан авалт оройтсон зэрэг шалтгаануудаас болсон байна.

ОНХС-д өмнөх оны малын тоо толгойн албан татварын үлдэгдэл 1.4 тэрбум төгрөг, тайланд онд малын татвараас 1.0 тэрбум төгрөг нийт 2.4 сая төгрөгийн эх үүсвэрээс 1.7 тэрбум зарцуулахаар баталж, гүйцэтгэлээр 1.3 тэрбум төгрөгийг зарцуулсан нь төсвийн төлөвлөлт болон хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

### **2.3 Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийн 68.8 хувийг насжилт өндөртэй авлага эзэлж байна.**

Хоршоо хөгжүүлэх сангийн зарлагын төлөвлөгөөг 4,080.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 778.7 сая төгрөгийг зарцуулж, биелэлт 19.1 хувь байна.

#### Хоршоо хөгжүүлэх сангийн гүйцэтгэл

Хүснэгт №15

/сая төгрөгөөр/

№	Сум	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Эцсийн үлдэгдэл
1	Баян-Адарга	98.5	0.1	93.5
2	Биндэр	161.7	0.1	135.6
3	Баянмөнх	120.6	-	121.5
4	Батноров	183.8	0.5	152.7
5	Баян-Овоо	167.6	30.1	122.3
6	Баянхутаг	59.2	-	30.7
7	Батширээт	112.4	0.1	89.6
8	Бэрх	180.0	-	143.3
9	Бор-Өндөр	629.1	0.1	329.9
10	Галшар	189.9	0.1	190.7
11	Гурванбаян	20.8	-	16.7
12	Дархан	295.9	90.2	155.3
13	Дадал	115.6	114.6	0.7
14	Дэлгэрхаан	85.3	-	54.4
15	Жаргалтхаан	164.6	1.1	123.5
16	Мөрөн	161.5	0.1	104.9
17	Норовлин	170.7	0.1	103.4
18	Хэрлэн баян улаан	9.9	-	7.9
19	Хэрлэн	788.8	412.2	221.1
20	Цэнхэрмандал	179.5	-	152.7
21	Өмнөдэлгэр	185.0	129.3	44.5
22	Өлзийт	0.5	-	5.7
	<b>Дүн</b>	<b>4,080.8</b>	<b>778.7</b>	<b>2,400.6</b>

Тайлант онд Баян-Овоо сум 1 зээлдэгчид 30.0 сая төгрөг, Дархан сум 3 зээлдэгчид 90.0 сая төгрөг, Дадал сум 10 зээлдэгчид 114.5 сая төгрөг, Хэрлэн сум 12 зээлдэгчид 400.0 сая төгрөг, Өмнөдэлгэр сум 2 зээлдэгчид 128.5 сая төгрөгийн зээл олгож, 15.7 сая төгрөгөөр сангийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн байна.

## Хоршоо хөгжүүлэх авлагын үлдэгдэл /насжилтаар/

Хүснэгт №16

/сая төгрөгөөр/

№	Сумд	Авлагын үлдэгдэл	Насжилтаар					
			0-1 жил	1-2 жил	2-3 жил	3-4 жил	4-5 жил	5 дээш жил
1	Галшар	109.5			109.5			
2	Баянхутаг	261.7						261.7
3	Баянмөнх	177.2						177.2
4	Дархан	169.6	169.6					
5	Дэлгэрхаан	274.0						274.0
6	Жаргалтхаан	177.8					177.8	
7	Цэнхэрмандал	139.3						139.3
8	Өмнөдэлгэр	349.3						349.3
9	Батширээт	216.3		36.0	50.0		30.8	99.5
10	Биндэр	212.2						212.2
11	Баян-Адарга	196.4		57.7		31.8		106.8
12	Дадал	307.5				307.5		
13	Норовлин	191.2						191.2
14	Батноров	158.2	40.0	18.5	99.7			0.0
15	Баян-Овоо	155.4						155.4
16	Мөрөн	193.9				28.3		165.6
17	Хэрлэн	1,372.1	1,372.1					
18	Гурванбаян	40.7						40.7
19	Хэрлэнбаян-Улаан	2.0						2.0
20	Өлзийт	0.2					0.2	
21	Бор-Өндөр	571.7						571.7
22	Бэрх	140.6						140.6
	<b>Нийт дүн</b>	<b>5,416.6</b>	<b>1,581.7</b>	<b>112.2</b>	<b>259.3</b>	<b>367.6</b>	<b>208.7</b>	<b>2,887.0</b>
	<b>Хувиар</b>	<b>100.0%</b>	<b>29.2%</b>	<b>2.1%</b>	<b>4.8%</b>	<b>6.8%</b>	<b>3.9%</b>	<b>53.3%</b>

Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг насжилтаар нь авч үзвэл 0-1 жил болсон авлага 29.2 хувь, 1-2 жил болсон авлага 2.1 хувь, 2-3 жил болсон авлага 4.8 хувь, 3-4 жил болсон авлага 6.8 хувь, 4-5 жил болсон авлага 3.9 хувь, 5 дээш жил болсон авлага 53.3 хувийг эзэлж байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэлд 3 болон түүнээс дээш жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн чанаргүй болсон авлагын үлдэгдэл 3,722.6 сая төгрөг буюу нийт авлагын 68.8 хувийг эзэлж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг баталсан байна. Сангийн зорилгыг сумдад үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодоор дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах гэж тодорхойлсон байна.

Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангийн орлогын гүйцэтгэл 24.6 хувь, зарлагын гүйцэтгэл 19.1 хувь, сангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,400.6 сая төгрөг, авлагын үлдэгдэл 5,416.6 сая төгрөг үүнээс насжилт өндөр 3,772.6 сая төгрөгийн авлага байгаа нь журмын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Сангийн журамд хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг дараах байдалтай баталсан байна.

Шалгуур үзүүлэлт

Хүснэгт №17

/сая төгрөгөөр/

№	Шалгуур үзүүлэлт	Зохистой харьцаа /Жилээр/
1	Зээлийн эргэн төлөлт	Нийт хөрөнгийн 30-аас доошгүй хувийг бүрдүүлсэн байх
2	Чанаргүй зээлийн хэмжээ	Нийт хөрөнгийн 10 хувиас бага байх
3	Хяналт тавих үйл ажиллагаа	Жилд 2-оос доошгүй удаа
4	Олон нийтэд тайлагнасан байх	Жилд 1-ээс дээш удаа
5	Тайлан мэдээ	Улирал бүр
6	Ажлын байр нэмэгдүүлсэн байх	10-аас дээш хувь тогтоох

Журамд сангийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг тухайн аймгийн Засаг даргад хариуцуулсан байна.

Иймд журамд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах, хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг бууруулах, сангийн эхний үлдэгдлийг бүрэн төлөвлөж эргэлтэд оруулах зэрэг тодорхой ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Илрүүлэлт:

Батноров сумын ЭМТ-д 0.5 сая төгрөг, ЕБС-д 2.0 сая төгрөг, Биндэр сумын ЗДТГ-т 0.6 сая төгрөг, Норовлин сумын Цэцэрлэгт 4.3 сая төгрөг нийт 7.3 сая төгрөгийн санхүүжилт илүү, Дадал сумын Соёлын төвд 0.8 сая төгрөг, Норовлин сумын Соёлын төвд 0.9 сая төгрөг, Өлзийт тосгоны ЗАА-д 4.2 сая төгрөг нийт 5.9 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Шийдвэрлэлт: Санхүүжилтийг илүү дутуу олгосон зөрчлийг таслан зогсоох 5 албан шаардлага өгсөн.

Баянхутаг сум орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дулааны шугамын ажлын санхүүжилтийг гэрээний дүнгээс 1.0 сая төгрөгөөр илүү шилжүүлж, Батширээт сумын ЗДТГ ажил олгогчийн төлөх НДШ-ийн зардлаас 5.4 сая төгрөгийн актын төлбөр төлж, Биндэр сумын ЗДТГ үндсэн үйл ажиллагааны санхүүжилтээс сумын ЕБС-д авьяас хөтөлбөрт 15.0 сая төгрөг, гадна орчныг тохижуулахад 10.0 сая төгрөг олгож, Бор-Өндөр сумын ЗДТГ цалингийн зардлаас газрын хянан баталгаажуулалтын гэрээний зардалд 4.5 сая төгрөгийг төлж, Жаргалтхаан, Цэнхэрмандал сумын Байгаль хамгаалах сангаас 13.8 сая төгрөгийг төлж төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан байна.

Шийдвэрлэлт: Гэрээний дүнгээс илүү олгосон 1.0 сая төгрөгийг төлүүлэхээр 1 төлбөрийн акт, зориулалт бус зарцуулсан 49.7 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага өгсөн.

**БҮЛЭГ 3. НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ****3.1 Нэмэлт санхүүжилтийн дансны эцсийн үлдэгдэл 222.6 сая төгрөг нь аймгийн захиалагчийн хяналт дансны үлдэгдэл байна.**

Орон нутгийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн харилцах дансны эхний үлдэгдэл 367.3 сая төгрөг байсан бол тайлант онд 3,838.8 сая төгрөгийн орлого төвлөрч, 3,983.5 сая төгрөгийг зарцуулан жилийн эцэст 222.6 сая төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого дараах эх үүсвэрүүдээс бүрдсэн байна. Үүнд:

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 50.6 сая төгрөг
- ✓ Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 47.5 сая төгрөг
- ✓ Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,677.9 сая төгрөг
- ✓ Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,062.8 сая төгрөг

Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийн 1.3 хувийг төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж, 1.2 хувийг Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, 43.7 хувийг дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, 53.7 хувийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого тус тус эзэлж байна.

**Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт**

Хүснэгт №18

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,983.5
УРСГАЛ ЗАРДАЛ	3,645.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,458.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8.4
Хангамж, бараа материалын зардал	115.8
Норматив зардал	5.2
Эд хогшил, урсгал засварын зардал	122.9
Томилолт, зочны зардал	24.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,049.8
Бараа үйлчилгээний бусад зардал	2,102.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	187.6
Засгийн газрын урсгал шилжүүлэг	61.4
Бусад урсгал шилжүүлэг	126.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	337.6
Барилга байгууламж	112.0
Бусад хөрөнгө	141.2
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	84.3

Тайлант онд нэмэлт төсвийн гүйцэтгэлээр 3,983.5 сая төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 1.0 сая төгрөг, орон нутгийн төсөвт 126.2 сая төгрөг төвлөрүүлснээс 121.9 сая төгрөгийг буцааж олгохоор санхүүгийн тайланд авлагаар тусгажээ.

## Нэмэлт санхүүжилтийн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

## Хүснэгт №19

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эрүүл мэндийн төвүүд	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	Захиалагчийн хяналт	Соёлын төв	Нийт
Эхний үлдэгдэл	47.1	0.6	319.3	0.3	367.3
Эцсийн үлдэгдэл			222.6		222.6

Нэмэлт санхүүжилтийн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэлд 18 байгууллагын 367.3 сая төгрөг байна. Үүний 12.8 хувь нь сумдын Эрүүл мэндийн төвүүд, 0.2 хувь нь Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, 0.1 хувийг Соёлын төв, 86.9 хувь нь Захиалагчийн хяналт /100180051410/ дансны үлдэгдэл байна.

Тайлант онд Захиалагчийн хяналт дансны эхний үлдэгдэл 367.3 сая төгрөг, 511.0 сая төгрөгийн орлого орж 607.7 сая төгрөгийн зарцуулалт хийгдэж 222.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

## Нэмэлт санхүүжилтийн тайлангийн орлого, зарлага

## Хүснэгт №20

/сая төгрөгөөр/

№	Дансны нэр	Мөнгөн дүн
1	100180000350 Хэ.Хөрөнгө оруулалтын барьцаа Төрийн сан	6.1
2	100180008300 Хэ.Спорт ЭШХО Төрийн сан	17.9
3	100180010300 Хэ.ЗГХЭГ ЭШХОр Төрийн сан	20.0
4	100180013300 Хэ.БОАЖС-ын ЭШХО Төрийн сан	24.6
5	100180015300 Хо.БШУСайдын ЭШХОр Төрийн сан	10.8
6	100180015300 Хэ.БШУСайдын ЭШХОр Төрийн сан	255.3
7	100180020300 Хэ.ЭМСайдын ЭШХОр Төрийн сан	11.5
8	100180029300 Хэ.БХБС ЭШХО Төрийн сан	112.3
9	100180030300 Хэ.ЭХСайд ЭШХО Төрийн сан	6.4
10	100180034300 Хэ.ССайдын ЭШХО Төрийн сан	44.3
11	100180039300 Хэ.ХНХСайдын ЭШХО Төрийн сан	0.6
12	100180051412 Хэ.Орон нутгийн замын сан Төрийн сан	1.1
	<b>Орлогын дүн</b>	<b>511.0</b>
1	05-0000-5315005406 Барилга байгууламж	19.4
2	15-0000-1105128096 Содон номин констракшн	19.2
3	15-0000-1415100862 Эсгий гүрэн	2.8
4	15-0000-1505012760 Хот төлөвлөлтийн хүрээлэн ХХК	1.6
5	15-0000-1805007593 Нарлаг хөхий ХХК	15.2
6	90-0000-100180000910 Хэ.Орон нутгийн ерөнхий орлого	100.0
7	90-0000-100180000955 Хэ.Бусад нэр заагдаагүй орлого	433.0
8	90-0000-100180029401 Хэ.ГХБХБГазар н.с	16.5
	<b>Зарлагын дүн</b>	<b>607.7</b>

Захиалагчийн хяналт дансанд ТЕЗ-ийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтын данснууд, орон нутгийн замын сан, хөрөнгө оруулалтын барьцаа данс зэргээс захиалагчийн хяналт, зураг төсвийн үнэ, нормчлолын сан гэсэн утгатай 511.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнээс захиалагчийн хяналт, зохиогчийн хяналт, хүчитгэлийн ажилд нийт 74.7 сая төгрөг зарцуулж, орон нутгийн ерөнхий орлого дансанд 100.0 сая төгрөг, нэр заагдаагүй бусад орлого дансанд 433.0 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсний 128.7 сая төгрөг нь аймаг дахь Төрийн аудитын газраас тогтоосон төлбөрийн акт байна.

Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.18 “Зураг төсөл боловсруулсан зардал, зохиогчийн хяналт болон захиалагчийн хяналтын зардлыг тухайн төсөл дээр байгуулсан гэрээ, хийсэн ажлын тайлангийн дагуу холбогдох норм дүрэмд заасныг үндэслэн энэ журмын хавсралт №16-д заасан маягтыг бөглөж олгоно” гэж заасан байна.

Орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн 404.3 сая төгрөг нь төсвийн орлого биш бөгөөд тухайн эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын дансны зарцуулагдаагүй үлдэгдэл юм. Иймд Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар

болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж зааснаар холбогдох ТЕЗ-ийн хөрөнгө оруулалтын дансанд төвлөрүүлж хуулийн хэрэгжилтийг хангах шаардлагатай байна.

Захиалагчийн хяналтыг хийсэн ажлын тайлан байхгүй, гүйцэтгэлийг журамд заагдсан маягтаар тайлагнаагүй, анхан шатны баримтын бүрдлээс захиалагчийн хяналтын хэрэгжүүлсэн эсэхийг бүрэн нягтлах боломжгүй байхад аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд захиалагчийн хяналтын зардлаас 30.7 сая төгрөг төвлөрүүлж зарцуулсан нь Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.18-ыг зөрчсөн байна.

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 “Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно” гэж заасан бөгөөд хяналтын чиг үүргийг хэсэгчлэн хэрэгжүүлэх талаар тодорхой тусгагдаагүй тул захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлж барилгын үйл ажиллагаанд холбогдох норм, нормативын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж хувийн, нийтийн болон гуравдагч этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах нь зүйтэй байна.

#### **БҮЛЭГ 4. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

Төрийн аудитын тухай хуульд заасан үндсэн зорилтын хүрээнд төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахад аудитын үйл ажиллагаа чиглэгдэж ирсэн. Засгийн газраас 2021 онд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэн ажиллах “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг батлан мөрдүүлсэн. Мөн 2022 оны 5 дугаар сард “Төрийн хэмнэлтийн тухай хууль” шинээр батлагдан мөрдөгдөж, энэ хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар Засгийн газрын 203, 204 дүгээр тогтоолоор батлагдсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол улсын Ерөнхий аудиторовын А/59 тоот тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэл”-ийг, А/89 тоот тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг тус тус баталсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зорилт нь төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой.

Дээрх зорилгын хүрээнд ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад хамааралтай шалгуур үзүүлэлтийн дагуу горим сорил гүйцэтгэхэд 350.5 сая төгрөгийн 38 зөрчил илэрснээс 32.1 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт, 298.6 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 20 албан шаардлага, 19.8 сая төгрөгийн 5 зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгч ажилласан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдийн хангамж болон зарим үйл ажиллагааг хязгаарласан, хориглосон байна.

Хуулиар хориглосон үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчил  
/Байгууллагын төрлөөр ангилан авч үзвэл/

## Хүснэгт №21

/сая төгрөгөөр/

№	Байгууллага	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах заалтууд: 6 дугаар зүйл, 8 дугаар зүйл, 12 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйлийн 15.1</b>							
1	Байгал орчин аялал зуучлалын газар	2	10.7				
2	Засаг даргын тамгын газар	7	19.1	3	25.3		
3	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	0.3	6	57.8		
4	Сум дундын ойн анги	1	1.2	1	1.8		
5	ОНӨААТҮГ			1	1		
6	Санхүүгийн хяналт аудитын алба	1	0.1				
7	<b>Нийт</b>	<b>12</b>	<b>31.4</b>	<b>11</b>	<b>85.9</b>		

Хуулиар хязгаарласан үйл ажиллагаатай холбоотой 117.3 сая төгрөгийн 22 зөрчил илэрснээс 31.4 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт, 85.9 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 11 албан шаардлага хүргүүлж шийдвэрлэсэн байна. Нийт зөрчлийн 87.3 хувь нь Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын байгууллагуудад гарсан байна.

Хуулиар хориглосон үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчил  
/Зөрчлөөр ангилан авч үзвэл/

## Хүснэгт №22

/сая төгрөгөөр/

Хуулийн заалт	Зөрчлийн товч утга	Төлбөрийн акт		Албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн
12.1.4	Байгаль орчин нөхөн сэргээх зардлаас аяллын төлбөр төлсөн.	1	10		
15.1.3	<b>Дэмжлэг:</b> Ажилтнууд-1.8 сая төгрөг, Ахмадын баяртай холбоотой-2.8 сая төгрөг, хүүхдийн бэлэг худалдан авахад 6.0 сая төгрөг тус тус зарцуулсан <b>Шагнал, урамшуулал:</b> Ахмадын баяртай холбоотой -3.1 сая төгрөг, Иргэдийн төлөөлөгчдийн урамшуулалд-48.6 сая төгрөг, Уралдаан тэмцээн-24.0 сая төгрөг	7	7.8	8	78.5
15.1.4	Баримтат кино хийхэд 10.0 сая төгрөг зарцуулсан.	1	10.0		
15.1.5	Төсвийн хөрөнгөөр бэлэг худалдан авсан.	2	1.0	1	5.2
6.3	Дотор ажилд тээврийн хэрэгсэл ашигласан.			2	2.2
8.1	Ажилтнуудад дүрэмт хувцас авсан.	1	2.6		
	<b>Дүн</b>	<b>12</b>	<b>31.4</b>	<b>11</b>	<b>85.9</b>

Дээрх хүснэгтээс харахад хуулиар хориглосон үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчлийн 73.6 хувь нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна. Уг зөрчлийн 12.3 хувь нь дэмжлэг үзүүлсэнтэй холбоотой 87.7 хувь нь шагнал урамшуулалтай холбоотой байна.

Хуулиар хязгаарласан үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчил  
/Байгууллагын төрлөөр ангилан авч үзвэл/

## Хүснэгт №23

/сая төгрөгөөр/

№	Байгууллага	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах заалтууд: 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйлийн 15.2</b>							
1	Засаг даргын тамгын газар			7	81.1	2	12
2	Иргэдийн төлөөлөгчдийн хурал			1	7.3	3	7.8
3	Сум дундын ойн анги	1	0.7				
4	Хэнтий ус ХХК			1	124.3		
	<b>Нийт</b>	<b>1</b>	<b>0.7</b>	<b>9</b>	<b>212.7</b>	<b>5</b>	<b>19.8</b>

Хуулиар хязгаарласан үйл ажиллагаатай холбоотой 233.2 сая төгрөгийн 15 зөрчил илэрснээс 0.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 212.7 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 9 албан шаардлага хүргүүлж, 19.8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгч шийдвэрлэсэн байна. Нийт зөрчлийн 46.4 хувь нь Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын байгууллагуудад, 53.6 хувь нь орон нутгийн өмчит байгууллагуудтай холбоотой байна.

Хуулиар хязгаарласан үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчил  
/Зөрчлөөр ангилан авч үзвэл/

Хүснэгт №24

/сая төгрөгөөр/

Хуулийн заалт	Зөрчлийн товч утга	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
14.5	Тендер шалгаруулалт зохион байгуулаагүй.			3	168.6		
15.2.1	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг хэмнээгүй.					1	10.1
15.2.3	Сургалт, семинар холбоотой томилолт, байр, шатахууны зарцуулалт хийсэн			4	32	1	1.1
15.2.4	Бичгийн цаас, хэвлэгч хувилагчийн хорны зардлыг хэмнээгүй.			1	5.8	3	8.6
15.2.6	Цалин хөлсийг үндэслэлгүй тогтоосон.	1	0.7	1	6.3		
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0.7</b>	<b>9</b>	<b>212.7</b>	<b>5</b>	<b>19.8</b>

Дээрх хүснэгтээс харахад хуулиар хязгаарласан үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчлийн 72.3 хувь нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Мөн зөрчлийн 14.2 хувь нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” заалтыг зөрчсөн, МУ-ын Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоол “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”-ын 1.3-д “Байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах” чиглэлийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосонтой нийцэхгүй байна.

Иймд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахын тулд төсөв захирагчид тендер шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж холбогдох зардлыг хэмнэх, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгодог зөрчлийг арилгах зэрэгт ТЕЗ анхаарч ажиллах шаардлагатай байна.

МУ-ын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолоор автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа автомашиныг тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасан байна.

## Тээврийн хэрэгслийн судалгаа

Хүснэгт №25

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Марк	Модель	Улсын бүртгэлийн дугаар	Балансын үнэ /сая.төг/	Шийдвэр	Хүлээн авсан газар
1	Аймгийн Засаг даргын тамгын газар	Kia	Sonota-7	00-42ХЭҮ	20.0	Аймгийн ИТХ-н 2023 оны 06 дугаар тогтоол	Хэнтий аймаг дахь цагдаагийн газар
2	Аймгийн Засаг даргын тамгын газар	Kia	Sonota-7	11-16ХЭА	20.0	Аймгийн ИТХ-н 2023 оны 06 дугаар тогтоол	Хэнтий аймаг дахь цагдаагийн газар
3	Аймгийн Засаг даргын тамгын газар	Toyota	Axio	00-04ХЭА	14.9	Аймгийн ИТХ-н 2022 оны 03 дугаар тогтоол	Дуудлага худалдаагаар зарагдсан
4	Аймгийн Засаг даргын тамгын газар	Toyota	Land-80	00-12ХЭА	15.8	Аймгийн ИТХ-н 2022 оны 03 дугаар тогтоол	Дуудлага худалдаагаар зарагдсан
5	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	Toyota	Probox	80-33ХЭА	15.0	Аймгийн ИТХ-н 2023 оны 06 дугаар тогтоол	Мөрөн сумын Эрүүл мэндийн төв
6	Боловсрол, шинжлэх ухааны газар	Kia	Carnival	25-50ХЭҮ	36.2	Аймгийн ИТХ-н 2023 оны 06 дугаар тогтоол	Шүүхийн шинжилгээний алба
7	Статистикийн хэлтэс	Toyota	Ланд-80	00-81ХЭА	32.0	Аймгийн ИТХ-н 2022 оны 03 дугаар тогтоол	Дуудлага худалдаагаар зарагдсан
<b>Нийт</b>					153.9		

Дээрх тогтоолын хүрээнд Хэнтий аймгийн хэмжээнд 153.9 сая төгрөгийн балансын үнэ бүхий 7 суудлын авто машиныг татан авч 62.7 сая төгрөгийн балансын үнэ бүхий 3 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаанд оруулж 19.0 сая төгрөгөөр худалдан борлуулж, 91.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий 4 тээврийн хэрэгслийг хэрэгцээ шаардлага үүссэн төрийн байгууллагад шилжүүлсэн байна.

Автомашин хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан гарсан МУ-ын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгаа нь төрийн байгууллагуудын авч хэрэгжүүлэх шат шатны арга хэмжээ хэрэгжээгүйтэй холбоотой байна.

**БҮЛЭГ 5. ӨМНӨХ АУДИТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ****5.1 Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100% байна.**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 3,991.0 сая төгрөгийн 5 зөрчил илэрснээс 3,991.0 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 4 зөвлөмж хүргүүлсэн байна. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг харуулбал.

**Зөвлөмжийн хэрэгжилт**

Хүснэгт №26

/сая төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Биелэлт	Байгууллагаас ирүүлсэн тайлбар, тодруулга
1	Дээд шатны төсөвт тодотгол хийгээгүй байхад 2021 оны 04 дүгээр сард 3,991.0 сая төгрөгөөр төсвийг тодотгосон нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалттай нийцэхгүй байна.	100%	Тайлант онд Төсвийн тухай хуульд нийцүүлэн төсвийн тодотголыг хийсэн байна
2	Аймаг, сумын төсвийн орлогын төлөвлөгөөг өмнөх онуудын гүйцэтгэл, цаг үеийн нөхцөл байдал зэрэгт дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй төлөвлөж, орлогыг нэр төрлөөр биелүүлж, гүйцэтгэлд хяналт тавих.	100%	Аймаг, сумын төсвийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, орлогыг нэр төрлөөр биелүүлэхэд анхаарч ажилласан.
3	Сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг аймгийн төсөвт татан төвлөрүүлэлтийг хууль тогтоомжид нийцүүлэх.	100%	Сумын төсвийн орлогыг аймгийн төсөвт татан төвлөрүүлэлгүй аймгаас олгох дэмжлэгийг бууруулахаар тооцож байна.
4	Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах.	100%	Шинээр батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр Засгийн газраас баталсан заавар журмыг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг сумдын Засаг дарга, байгууллагын төсөв захирагч нарт хүргүүлэн ажилласан.
5	Орон нутгийн өмчийн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулах, хөрөнгө зарцуулах тухай шийдвэрийг үндэслэлтэй гаргах, гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах.	100%	Орон нутгийн өмчийн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулах, хөрөнгө зарцуулах тухай шийдвэрийг үндэслэлтэй гаргах, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг ОНӨГ-т хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.
<b>Зөрчлийн дүн</b>		<b>100%</b>	

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар 399.4 сая төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт 7,882.3 сая төгрөгийн 8 зөрчил илэрснээс 1,929.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 5,952.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүллээ.

Аймгийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр 53,784.9 сая төгрөгийн нийт орлого ба тусламж, 53,952.1 сая төгрөгийн нийт зарлага ба зээлийн дүнг аудитаар баталгаажуулав.

- Аймгийн төсвийн нийт орлого 26,530.0 сая төгрөгөөр буюу 121.8 хувиар давж биелсэн байна.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь аймгийн төсвийн орлогод төвлөрүүлдэг болсонтой холбоотойгоор 2,002.6 сая төгрөгийн орлогыг урьдчилан авч өр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулиар тодорхойлсон төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчимд нийцэхгүй байна.
- Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын гүйцэтгэл 75.4 хувиар буюу 1,003.2 сая төгрөгөөр тасарсан байна.
- Нэгдсэн төсвийн нийт урсгал зардлын гүйцэтгэл 84.6 хувьтай байна.
- Автомашины хэрэглээг Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хязгаарласантай холбогдуулан гарсан МУ-ын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.
- Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэр болон зарцуулалтыг бүрэн төлөвлөхгүй байна.

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

- Аймаг, сумын төсвийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, орлогыг нэр төрлөөр биелүүлж, гүйцэтгэлд хяналт тавих.
- Сумын төсөвт баталсан ИТХ-ын тогтоолыг үндэслэн төсвийн төлөвлөгөө, хөтөлбөр, арга хэмжээ, гүйцэтгэлийг төсвийн программд үнэн, зөв оруулж байх.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг урьдчилж авахгүй байх.
- Байгаль хамгаалах сангийн дансыг байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагааны барьцаа хөрөнгийн данс байдлаар ашиглах, дансны нэрийг барьцаа хөрөнгийн данс болгож өөрчлөх
- Орон нутгийн төсвийн суурь зардлыг төлөвлөхдөө “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ыг баримтлан тооцоолол хийх
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон хуулийг хэрэгжүүлэхээр гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах.
- Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг бууруулах талаар холбогдох журам зааврыг үндэслэн тодорхой арга хэмжээ авч ажиллах.

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ САНАЛ

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол улсын Ерөнхий аудиторын А/59 тоот тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэл”-ийг, А/89 тоот тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг баримтлан шалгагдагч байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах хүндрэл гарч байна. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой цахим дэлгүүрт оруулах, бараа, үйлчилгээний тоо хэмжээ, гэрээ байгуулсан нэгж үнийн талаарх санал, мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлдэггүй, цахим дэлгүүрийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажил хангалттай хийгдээгүй, дэлгүүрт байршуулах бараа, үйлчилгээний нэр төрөл цөөн, хэрэгцээ шаардлага хангахгүй байгаа зэрэг нь хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлэхэд хүндрэл үүсгэж байна. Иймд цахим дэлгүүрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг холбогдох байгууллагад уламжлах шаардлагатай байна.
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдийн хангамж болон зарим үйл ажиллагааг хязгаарлаж, хориглосон болон тодорхой зардлуудыг хэмнэж ажиллах зохицуулалттай. Хэмнэх зардлуудыг хэрхэн хэмжих, ямар түвшний суурь үзүүлэлттэй харьцуулж үнэлэх, үр дүнг яаж үнэлэх зэрэг нарийвчилсан, аргачлал зохицуулалт шаардлагатай байна.
3. Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан гарсан МУ-ын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна. Энэ нь тогтоолд дурдагдсан төрийн байгууллагуудын авч хэрэгжүүлэх арга хэмжээ хангалтгүй байгаагаас шалтгаалан хуулийн хэрэгжилтийг хангуулахад хүндрэлтэй байна. Иймд тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх санал чиглэлийг холбогдох байгууллагуудад уламжилж өгнө үү.

## АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хүснэгт №27

/сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	II НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	63,761.45	53,952.12	9,809.33	84.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,122.90	34,236.12	3,886.78	89.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	35,467.79	31,760.63	3,707.17	89.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,487.04	9,650.47	836.57	92.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,322.71	1,212.85	109.86	91.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,313.44	9,679.40	1,634.03	85.56
2104	Хангамж, бараа материалын зардал	876.31	823.58	52.73	93.98
2105	Нормативт зардал	185.26	184.21	1.05	99.43
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,471.44	1,436.33	35.11	97.61
2107	Томилолт, зочны зардал	232.18	224.04	8.14	96.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,576.33	5,031.43	544.90	90.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,003.08	3,518.30	484.77	87.89
211	ХҮҮ	344.36	344.36	-	100.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	344.36	344.36	-	100.00
212	ТАТААС	388.70	287.09	101.61	73.86
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	20.00	7.09	12.91	35.47
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	368.70	280.00	88.70	75.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,922.04	1,844.03	78.01	95.94
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	840.33	828.99	11.33	98.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,081.72	1,015.04	66.68	93.84
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,620.69	18,952.74	2,667.95	87.66
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	4,017.86	763.26	3,254.60	19.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	63,761.45	53,784.86	9,976.59	84.35
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	56,691.08	52,461.82	4,229.26	92.54
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,070.37	1,323.04	5,747.33	18.71
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,626.90		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,450.96		

**АУДИТЛАГДСАН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

Хүснэгт №28

/сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,983.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,645.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,458.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8.43
2104	Хангамж, бараа материалын зардал	115.79
2105	Нормативт зардал	5.17
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	122.91
2107	Томилолт, зочны зардал	24.21
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,049.78
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,102.55
211	ХҮҮ	0
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0
212	ТАТААС	0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	187.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	61.38
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	126.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	337.63
2200	Дотоод эх үүсвэрээр	337.63
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,838.78
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,838.78
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-144.71
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	367.30
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	222.59

**Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

Хүснэгт №29

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
1	Хэнтий аймгийн ТЕЗ	44	799.6	11	229.7	16	229.8	17	340.1		
<b>ДҮН</b>		<b>44</b>	<b>799.6</b>	<b>11</b>	<b>229.7</b>	<b>16</b>	<b>229.8</b>	<b>17</b>	<b>340.1</b>		
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>											
	Хэнтий аймгийн ТЕЗ	38	350.5			13	32.1	20	298.6	5	19.8
<b>ДҮН</b>		<b>38</b>	<b>350.5</b>			<b>13</b>	<b>32.1</b>	<b>20</b>	<b>298.6</b>	<b>5</b>	<b>19.8</b>
<b>НИЙТ ДҮН</b>		<b>82</b>	<b>1,150.1</b>	<b>11</b>	<b>229.7</b>	<b>29</b>	<b>261.9</b>	<b>37</b>	<b>638.7</b>	<b>5</b>	<b>19.8</b>



**МОНГОЛ УЛС**  
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА**

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,

Чингис хот, Хэнтий аймаг, 23000

Утас/Факс: (976) 7056 2151

Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2023. 05. 02 № 9/923

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**  
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитаас өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж, цаашид зөрчлийг арилган ажиллах болно.



Ц.ЧОГСОМЖАВ

231050312



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2023 оны 05 дугаар сарын 08

Дугаар А/Н

Чингис хот

Аудитын тайлан  
баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хэнтий аймгийн Засаг даргын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайланг баталсугай .
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга болон ИТХ-ын даргад тус тус хүргүүлж, хураангуй тайланг [open.audit.mn](http://open.audit.mn) сайтад байршуулсугай.
3. Аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
4. Аудитаар хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /Г.Энх-Амгалан/-д даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Д.Оюунтуяа/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

232310015



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 дугаар сарын 02

Дугаар 195/А2370451  
ХАА-2023/01/НА-СТА-ТЭЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллагаар тулгахад Засаг дарга дансанд 293.2 сая төгрөг, Орон нутгийн хөрөнгө оруулалтад 562.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг хэлнэ, 14 дүгээр зүйлийн 14.2.1-д "жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах", 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэснийг мөрдөн ажиллаагүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг хуваарийн дагуу олгодоггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Ц.Чогсомжав, нягтлан бодогч Д.Цэцэгсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ОЮУНТУЯА

АУДИТОР  Ц.ХАТАНБОЛД

2317144297  
СИОА0043 967 082

232340538



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 дугаар сарын 02

Дугаар 196/А2370451

Чингис хот

ХБА-2023/01/ХА-СТА-ТЭС

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын хэмнэлтээс 330.0 сая төгрөгийг урсгал засварын зардалд шилжүүлэн зохицуулалт хийж зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал"-ын "Гурав" дугаар зүйлийн 3.6.1-д "үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөд хийх урсгал засварын зардлыг үлдэгдэл өртгөөс дараах хувь хэмжээгээр тооцож төлөвлөнө" гэснийг мөрдөн ажиллаагүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын төсвийн байгууллагын урсгал засварын зардлыг үндэслэлтэй төлөвлөдөггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Ц.Чогсомжав, нягтлан бодогч Д.Цэцэгсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

АУДИТОР

Ц.ХАТАНБОЛД

2317144297  
СЮА0046 907 082

232340542



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 дугаар сарын 02

Дугаар 197/А2370051

Чингис хот

ХЭА - 2023/01/АА - СТА - ТБЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын хэмнэлтийн 1,634.0 сая төгрөгөөс 744.2 сая төгрөг нь үндэслэлгүй төлөвлөгдсөн зардал байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг үндэслэлтэй төлөвлөдөггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Ц.Чогсомжав, нягтлан бодогч Д.Цэцэгсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

АУДИТОР

Ц.ХАТАНБОЛД

2317141237  
СИА0046 907-082

232340539